



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНХУТАГ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2024 оны 12 сарын 23 өдөр

Дугаар А/30

Баянхутаг сум


Хөрөнгө орлогод авч бүртгэх тухай

Монгол улсын Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, дэхь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.3 дахь заалт Баянхутаг сумын засаг даргын 2024 оны 08 сарын 30-ны өдрийн А/86, 2024 оны 07 сарын 08-ны өдрийн А/71 тоот захирамжуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Суралцагчдын гоо зүйн болон бие бялдарын хөгжлийг дэмжих, чөлөөт цагийг зөв өнгөрүүлэх орчин нөхцлийг сайжруулах хүрээнд ОНХСангийн хөрөнгөөр хийгдсэн “Сургуулийн урлаг заал” 140,380,645 /Нэг зуун дөчин сая гурван зуун наян мянга зургаан зуун дөчин таван/ төгрөг, “Хүүхэд залуучуудын биеийн тамирын талбай” 112,217,267 /нэг зуун арван хоёр сая хоёр зуун арван долоон мянга хоёр зуун жаран долоон/ төгрөгийн бүтээн байгуулалтуудыг барилга байгууламжийн дансанд бүртгэхийг нягтлан бодогч /Н. Ууганнавч/-д зөвшөөрсүгэй.

2. Дээрх хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж ажиллахыг нярав /Д. Алтантуяа/-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Г.ГАНБОЛД